




ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ТҮРГЭВЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Шинэ төрлийн коронавирус буюу COVID 19 цар тахлын улмаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ (хөл хорио тогтоох, онцгой нөхцөл байдал зарлах) нь ЖСХ ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх хамгаалалд хэрхэн нөлөөлж буй нөлөөлөл, шалтгааныг тогтоох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хохирогч хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээнд хэрхэн нөлөөлж байгаад үнэлгээ хийх замаар тулгамдаж байгаа асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох үнэлгээ

Тайлан бэлтгэсэн:

М.Чанцалсүрэн, Зөвлөх

Б.Цогбаяр, Зөвлөх

НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлагийн техник аргазүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар зөвлөх үйлчилгээний хүрээнд гүйцэтгэв.

2020 оны 5 сар

ТОВЧИЛСОН ҮГ

БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
БЗД	Баянзүрх дүүрэг
БТ	Баривчлах төв
ГБТ	Гэр бүлийн тухай хууль
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТТ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГХЗУСТ	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хууль
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ЖСХ	Жендэрт суурилсан хүчирхийлэл
ЗТХ	Зөрчлийн тухай хууль
НЦГ	Нийслэлийн цагдаагийн газар
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
МАХХ	Монголын ахмадын холбоо
МЭХ	Монголын эмэгтэйчүүдийн холбоо
ТББ	Төрийн бус байгууллага
ТХБ	Түр хамгаалах байр
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ХБ	Хамтарсан баг
ХЗДХЯ	Хууль зүйн дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХИТ	Хүүхэд хөгшдийг ивээх төв
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХ	Эрүүгийн хууль
COVID 19	Шинэ төрлийн коронавируст цар тахал

АГУУЛГА

Нэг. УДИРТГАЛ	3
Хоёр. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ.....	4
Гурав. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ	8
Дөрөв. ЗӨВЛӨМЖ	25
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	28
ХАВСРАЛТ 1.....	29

Нэг. УДИРТГАЛ

Үндэслэл

БНХАУ-ын Ухань хотод 2019 оны 12-р сард тархаж эхэлсэн шинэ төрлийн корона вирус COVID 19 цар тахлын улмаас Монгол Улс өндөржүүлсэн бэлэн байдлын хүрээнд хөл хорио тогтоогоод байна. Үүний улмаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, их, дээд сургуулиуд, мэргэжлийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарласнаар 900 орчим цэцэрлэг, сургуулийн хүүхдүүд гэрээрээ ТВ хичээл үзэж байгаа бөгөөд олон тооны хүүхдүүд гэртээ эцэг эхийн хараа хяналтгүй үлдэж байна. Түүнчлэн энэхүү онцгой нөхцлийн үед олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, үзвэр үйлчилгээг хааж, зарим байгууллагуудын ажилтан, албан хаагчид гэрээсээ ажиллах шаардлагатай болсон ба нийт иргэдийн ажил, гэр бүлийн амьдрал дах өдөр тутмын хэв маягт ихээхэн өөрчлөлт ороод байна. Мөн 4 сарын 30 хүртэл хилээр орох гарах хөдөлгөөнийг хориглосон шийдвэрийг 6 сарын 30 хүртэл сунгаад байна.

COVID 19 цар тахал нь Монгол улс төдийгүй бусад улс оны иргэд, төр засаг, нийгэмд шинээр тулгамдсан асуудлууд, тэдгээрийг даван туулах сорилт, шаардлагуудыг бий болгож байна.

Цар тахлын дэгдэлтийн үед үүсэж болох эрсдэлийг бууруулах, хохирлоос иргэдээ хамгаалах чухал аргуудын нэг нь хязгааралт буюу хөл хорио тогтоох явдал юм. Манай улсын хувьд “хөл хорионы дэглэм” тогтоон ажиллаж байгаа нь үр дүнгээ өгч буй хэдий ч эдгээр өдрүүдэд зарим төрлийн гэмт хэрэг тухайлбал ахуйн хүрээнд хүчирхийлэл өсөх хандлага ажиглагдаж байна.

Хөл хорио тогтоосон өдрүүдэд гэмт хэргийн дуудлага мэдээлэл багассан боловч гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн дуудлага мэдээлэл өссөн үзүүлэлттэй байна. Улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сард нийт 8003 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 19,2 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 27,2 хувиар тус тус буурсан боловч 3-р сард гарсан ийм төрлийн гэмт хэргийн тоо өссөн, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61,6 хувиар өссөн байна. Хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээ, хамгаалах байранд үйлчлүүлсэн иргэдийн тоо 88 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эдгээр өсөж буй тоон үзүүлэлттэй холбогдуулан хөл хорионы хугацаанд хүн амын дунд гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал болон хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлж буй НЦҮТ, ТХБ-нд хандах иргэдийн тоо өссөн учир шалтгааныг тодруулах шаардлагатай байна. Түүнчлэн хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд тохиолдож буй бэрхшээл, хүндрэлийг хэрхэн даван туулж байгаа, цаашид онцгой байдлын нөхцөлд хохирогч хамгааллын тогтолцооны бэлэн байдлыг хангах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага байгаа эсэх талаар түргэвчилсэн үнэлгээ хийх замаар зөвлөмж гаргах хэрэгцээ байна.

Зорилго

Шинэ төрлийн коронавирус буюу COVID 19 цар тахлын улмаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ /хөл хорио тогтоох, онцгой байдал зарлах гм/ нь хүн амын өдөр тутмын

амьдралын хэм маягт өөрчлөлт оруулснаар стрессийн түвшин нэмэгдэхэд нөлөөлсөн нь жендерт суурилсан хүчирхийлэл ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх хамгаалалд хэрхэн нөлөөлж буй нөлөөллийг тогтоох, улмаар урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, хохирогч хамгаалал, нөхөн сэргээх үйлчилгээнд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх замаар тулгамдаж байгаа асуудлууд, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох явдал юм.

Хоёр. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Ажлын хүрээ

Зөвлөх ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд ажлын нарийвчилсан төлөвлөгөөг хавсралтаар батлуулсан болно.

1. ЖСХ/ГБХ-ийн тоо мэдээлэлийн сантай болон хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас (Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрууд) ЖСХ/ГБХ-ийн тоо мэдээллийг авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж, тоо мэдээлэл болон чанарын судалгаанд тулгуурлан хүчирхийлэлийн нөхцөл байдалд нөлөөлсөн хүчин зүйлс болон тулгамдсан асуудлуудыг тодорхойлов.
2. Шинэ төрлийн коронавирус буюу COVID 19 цар тахлын улмаас тогтоосон онцгой нөхцөл байдал, хөл хорио нь жендерт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх хамгаалал болон хохирогч хамгааллын үйлчилгээнд хэрхэн нөлөөлж буй нөлөөллийг тогтоон ажиллалаа. Үүнд:
 - i) ГБХ-ийн асуудлаар ажилладаг мэргэжлийн хүмүүстэй ганцаарчилсан ярилцлага хийв. Тухайлбал, ХНХЯ, ХЗДХЯ, ЭМЯ, БСШУСЯ, ЦЕГ, ГХУСАЗЗ, ГБХЗХГ, ШШГГ-ын харьяа баривчлах төв, ХЭҮТ, хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх НЦҮТ-үүд, ТХБ-ын ажилтнуудтай ярилцлага хийж, ЖСХ/ГБХ нэмэгдэхэд нөлөөлж байгаа нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн шалтгаанууд, мөн үйлчилгээ үзүүлэхэд тулгарч буй бэрхшээл, хэрхэн шийдвэрлэж байгаа, цаашид онцгой байдлын нөхцөлд ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, үйлчилгээ үзүүлэх, хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг хангахад юу хийх шаардлагатай болох талаарх тэдний санал бодлыг сонсов /Нийт 46 хүнтэй ярилцлага хийв/.
 - ii) ШШГГ-ын харьяа баривчлах төвд байгаа хүчирхийлэл үйлдэгчидтэй /10 хүнтэй/ ярилцлага хийж хүчирхийлэл үйлдэх болсон нөхцөл байдал, шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлохоос гадна баривчлах төвд үзүүлж буй үйлчилгээ, зан үйлийг өөрчлөх сургалтын чанар, цаашид анхаарах асуудлуудын талаар санал бодол солилцов.
 - iii) НЦҮТ болон Түр хамгаалах байранд үйлчлүүлж байгаа хохирогчидтой /14 хүнтэй/ уулзаж ярилцаж хүчирхийлэлд өртөхөд нөлөөлсөн хүчин зүйл болон хүчирхийллийн нөхцөл байдлын талаар тодруулж, мөн тэдэнд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, цаашид сайжруулах шаардлагын талаархи саналыг сонсож ярилцав. /Баянзүрх дүүрэг, Хан Уул дүүрэг, Гэмтэлийн эмнэлэг, Хүчирхийллийн эсрэг Үндэсний төв, Нийслэлийн Цагдаагийн дэргэдэх түр

хамгаалах байрны НЦҮТ, Говь-Алтай, Баянхонгор, Дархан-Уул болон Хөвсгөл аймгийн НЦҮТ -үүдээр очиж нөхцөл байдалтай танилцсан болно./

- iv) Хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настны эрх хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 4 ТББ-ын ажилтнууд, сургуулийн нийгмийн ажилтан болон хороо дүүрэгт ажилладаг хамтарсан багийн гишүүд /нийгмийн ажилтан/-тай /9 хүн/ уулзаж ярилцан, цар тахлын үед ЖСХ/ГБХ-ийн нөхцөл байдал, мөн хариу арга хэмжээ үзүүлэхэд тулгарч байгаа асуудлуудыг тодруулав.

3. Цаашид хорио цээрийн дэглэмийн үед ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хохирогчийг хамгаалах, мөн хохирогч хамгааллын үйлчилгээ тогтолцооны онцгой байдлын үе дэх нөхцөл байдлын талаар дүгнэлт өгч шийдвэрлэх асуудлын талаар зөвлөмж гаргасан.

- Шинэ төрлийн коронавирус буюу COVID 19 цар тахлын улмаас ЖСХ/ГБХ –ийн өсөлт бууралт, түүнд нөлөөлөсөн хүчин зүйлүүд, хохирогч хамгааллын тогтолцоо, үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд тулгарч байгаа асуудлууд, онцгой байдлын үед хохирогчдод үзүүлэх нэн шаардлагатай үйлчилгээг үзүүлэхэд НЦҮТ болон ТХБ-уудын бэлэн байдлыг хангах чиглэлээр зөвлөмж бүхий үнэлгээний тайлан боловсруулж ажиллав.

Судалгааны арга зүй

Түргэвчилсэн үнэлгээг хийхдээ НҮБХАС-ын Ази Номхон Далайн Бүсийн /АНДБ/ Оффисоос бэлтгэн гаргасман КОВИД 19- цар тахлын үед ЖСХ/ГБХ-ийн тоо мэдээлэл цуглуулахдаа анхаарах асуудлуудын талаархи мэргэжлийн зөвлөмж удирдамжийг удирдлага болгосон бөгөөд ЖСХ/ГБХ-ийн асуудал нь эмзэг асуудал бөгөөд үүнтэй холбоотой мэдээлэлийг цуглуулахад хүчирхийллийн хохирогчдыг эрсдэлд оруулах магадлал өндөр учраас АНДБ-ын оффисын зөвлөхүүдийн /Хэнриеттэ Янсан, Ингрид Фитзжералд, Сужата Туладхар/ саналыг зөвлөхүүдийн ажлын удирдамж болон судалгааны арга зүйг боловсруулахад авч ажилласан.

Тус үнэлгээний явцад онцгой нөхцөл байдлын үед ЖСХ/ГБХ-ийн талаар өргөн хүрээтэй мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх шаардлагатай болсон тул судалгаа шинжилгээний дараах аргуудыг хэрэглэсэн болно:

1. ЖСХ/ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээлэл, хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас холбогдох тоон мэдээллийг авч дүн шинжилгээ хийв.
2. Чанарын судалгааны арга болох ганцаарчилсан ярилцлагаар холбогдох мэргэжилтнүүд, албан хаагчид /хөтөлбөрийн зохицуулагчид, үйлчилгээ үзүүлэгчид/, ЖСХ/ГБХ-ийн хохирогчид /НЦҮТ болон хамгаалах байранд байрлаж байгаа хохирогчидтой/ болон хүчирхийлэл үйлдэгчидтэй /баривчлах байранд 7-30 хоног саатуулагдаж байгаа хүмүүс/ уулзаж ярилцав. Ярилцлагыг хийхдээ эмэгтэйчүүдийн аюулгүй байдлыг чухалчлан үзсэн бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгсдийг саатуулдаг баривчлах байранд саатуулагдсан хүчирхийлэл үйлдэгчдэд хийх зан үйл өөрчлөх албадан сургалтыг сайжруулах чиглэлээр НҮБХАС дэмжлэг үзүүлэн ажилладаг хамтын ажиллагааны хүрээнд хүчирхийлэл үйлдэгчидтэй ярилцлага хийх боломжийг бүрдүүлсэн болно.

3. Мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээ мэдээлэлд холбогдох тоон болон чанарын дүн шинжилгээ хийж харьцуулсан болно.

Чанарын судалгааны асуултуудыг тус үнэлгээний зорилгод үндэслэн боловсруулсан бөгөөд ярилцлагын ерөнхий агуулгыг мэргэжлийн чиг үүрэг, онцлогт нийцүүлэн бэлтгэв. Хавсралт 1-ийг үзнэ үү. Түүнчлэн судалгааны арга зүйг боловсруулахдаа дараахь асуултуудыг удирдлага болгосон болно.

- ЦЕГ болон НЦҮТ, хамгаалах байрны тоо мэдээллүүдээс харахад 2020 оны эхний улирлын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл болон үйлчлүүлсэн хүмүүсийн тоо нэмэгдсэн байгаа нь КОВИД 19 цар тахлын улмаас авсан хөл хорио, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, үйлчилгээ болон сургууль соёлыг хаасантай холбоотой эсэх? Хэрвээ тийм бол дээрх арга хэмжээнүүд гэр бүлийн хүчирхийлэл ихсэхэд хэрхэн нөлөөлсөн болон ямар тодорхой хүчин зүйлүүд илүүтэй нөлөөлсөн бэ? Хэрвээ үгүй бол энэхүү өсөлтөд өөр ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ?
- НЦҮТ болон түр хамгаалах байраар үйлчлүүлсэн хүмүүсийн тоо хэрхэн өсч, буурсан бэ? Яагаад?
- НЦҮТ болон түр хамгаалах байраар үйлчлүүлсэн иргэдэд шаардлагатай үйлчилгээг бүрэн үзүүлж чадсан эсэх? Үйлчилгээ үзүүлэх боломжид нөлөөлсөн хүчин зүйл байна уу?
- 2020 оны эхний улиралд гарсан гэнэтийг цочмог өсөлтийг НЦҮТ болон түр хамгаалах байруул хэрхэн даван туулсан бэ?
- НЦҮТ болон түр хамгаалах байрууд одоогийн хүчин чадлаараа шаардлагатай үйлчилгээг үзүүлэх боломжтой байсан эсэх? Хэрвээ үгүй бол ямар бэрхшээл тулгарсан бэ?
- НЦҮТ болон түр хамгаалах байрууд онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөөтэй эсэх?
- НЦҮТ болон түр хамгаалах байрууд КОВИД19 цар тахлын үед үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар мэдлэгтэй эсэх?
- 2020 оны үлдсэн хугацаанд үйлчилгээг үр дүнтэй үзүүлэхэд юу шаардлагатай вэ?, сайжруулах шаардлагатай ямар асуудлууд байна вэ?

Чанарын судалгаанд оролцогчдыг дараах дөрвөн бүлэгт хувааж нийт 79 хүнтэй биечлэн уулзаж ярилцсан болно:

- Үйлчилгээ үзүүлэгч: 46
- Хохирогч: 14
- Хүчирхийлэл үйлдэгч: 10
- Төрийн бус байгууллагын ажилтан: 9

Хөдөө орон нутагт Говь-Алтай аймгийн ХГБХГ-ын мэргэжилтнүүд, мөн аймгийн НЦҮТ-зохицуулагч, Баянхонгор аймгийн НЦҮТ-ийн нийгмийн ажилтан, зохицуулагчид, Дархан-Уул болон Хөвсгөл аймгийн НЦҮТ-үүдийн ажилтнуудтай биечлэн уулзаж мэдээлэл цуглуулсан болно. Түүнчлэн улсын хэмжээнд ажиллаж буй нийт 15 НЦҮТ-үүдийн холдбогдох хүмүүстэй утсаар ярилцаж нөхцөл байдлыг тодруулсан.

Үнэлгээний ажлын ёс зүй, хязгаарлагдмал байдал

Үнэлгээний явцад ЖСХ/ГБХ-ийн хохирогчид болон хүчирхийлэл үйлдэгчдээс албан ёсны зөвшөөрлийг авч, холбогдох талуудын хувийн нууцлалыг ханган ажиллахад анхаарч судлаачийн ёс зүйг баримтлан ажиллалаа.

Судалгааны үед дараахь зарчмуудыг анхааран ажилласан. Үүнд:

- НЦҮТ болон түр хамгаалах байраар үйлчлүүлж байгаа болон утсаар ярилцлага өгч байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг онцлон анхаарах,
- Судалгаанд оролцогчдын хувь хүний халдашгүй байдлыг хүндэтгэн, нууцлалыг хадгалах. Ярилцлага эхлэхээс өмнө судалгааны талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, зөвшөөрлийн хуудсанд гарын үсгийг зуруулах,
- Судалгаанд оролцогчдоос асуулт асуух, тэдэнтэй ярилцах үедээ тэдний сэтгэцийн эрүүл мэндийн байдал, стрессийн түвшинг онцлон анхаарна.

Энэхүү түргэвчилсэн үнэлгээ нь дараах хэд хэдэн хязгаарлагдмал талыг агуулж байсан.

Нэгдүгээрт, үнэлгээний хамрах хүрээ нь цаг хугацаа болон нөөцийн хувьд хязгаарлагдмал байлаа. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ГБХ-ийн асуудлаар ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд тухайлбал ХНХЯ, ХЗДХЯ, БСШУСЯ, ЦЕГ, ГХУСАЗЗ, ГБХЗХГ, ШШГГ-ын харьяа баривчлах төв, ХЭҮТ, МАХХ, МЭХ, ХХИТ, хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх НЦҮТ-үүд, ТХБ-ууд энэхүү үнэлгээнд хамрагдсан бол хөдөө орон нутгийн хувьд зөвхөн Говь-Алтай аймгийн ХГБХГ-ын мэргэжилтнүүд, мөн аймгийн НЦҮТ-ийн зохицуулагч, Баянхонгор аймгийн НЦҮТ-ийн нийгмийн ажилтан, зохицуулагч, Дархан-Уул аймгийн НЦҮТ-ийн ажилтнууд, Хөвсгөл аймгийн НЦҮТ ажилтнуудтай уулзсанаар үнэлгээний ажил хязгаарлагдсан болно. Засгийн газраас тогтоосон аялалын хязгаарлалт нь аймаг, орон нутаг, алсын дүүргүүдийн НЦҮТ болон түр хамгаалах байранд очиж уулзах явдал хязгаарлагдсан.

Хоёрдугаарт, үнэлгээний түүврийн хэмжээ бага, тухайлбал цаг хугацаа, нөхцөл байдлын улмаас тодорхой тооны хохирогч болон хүчирхийлэгчтэй уулзсан. Эхний 3 сарын тоо мэдээллээс харахад НЦҮТ болон хамгаалах байраар үйлчлүүлсэн иргэдийн тоо өссөн байдалтай байсан боловч судалгааг хийх үе буюу 4 сард НЦҮТ болон хамгаалах байраар үйлчлүүлж байгаа хохирогчдын тоо эрс буурсан тул хохирогчидтой ярилцлага хийхэд бэрхшээлтэй байгаа нь ажиглагдсан. Энэ нь цар тахлын улмаас авч хэрэгжүүлсэн хөл хорионы улмаас хүчирхийллийн хохирогчид хүчирхийлэл үйлдэгчийн хамт гэртээ байхад хүрсэн нь тэдний зүгээс хүчирхийлэлд өртсөн тохиолдолд тусламж авах, үйлчилгээнд хамрагдах байдал бэрхшээлтэй болсонтой холбоотой байсан байх магадлалтай. Гэвч 5 сар гармагц үйлчлүүлэгчдийн тоо эргээд нэмэгдэх хандлагатай болсон нь цар тахлын улмаас авсан хөл хорио 4 сар гаруй үргэлжилж байгаа нь хүмүүсийн зүгээс хөл хориог мөрдөх байдал суларсан байж болох юм гэж үзсэн.

Гуравдугаарт, байгууллагуудын цуглуулсан тоон үзүүлэлтийг нэгтгэн дүгнэх явцад зөвхөн хувь бодох болон харьцуулах зэрэг статистик дүн шинжилгээний аргуудыг ашигласан болно. ЦЕГ дээрх гэр бүлийн хүчирхийллийн тоо мэдээллийн сан болон НЦҮТ-ийн үйлчилгээний тоо мэдээллийг ашиглахдаа эдгээр тоо мэдээллийг хүчирхийллийн тархалтын тоо мэдээллийн төлөөлөл болгон ашиглаж болохгүй гэдгийг онцлон анхаарч ажилласан бөгөөд зөвхөн цар тахлын улмаас ЖСХ/ГБХ-ийн

мэдээлэгдсэн байдал нэмэгдсэн эсвэл буурсан болон шалтгааныг шинжлэхэд уг мэдээллийг ашигласан болно.

Гурав. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

Хөл хорионы улмаас өрхийн орлого нь зөвхөн бизнесээс хамааралтай зарим хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаа хязгаарлагдсан нь гэр бүл дэх стресс дарамтыг нэмэгдүүлж гэр бүлийн хүчирхийллийг өдөөх шалтгаан болсон байна.

- i) Эмэгтэйчүүдийн ихэнх нь үйлчилгээний байгууллага тухайлбал нийтийн хоол, ресторан, бар, болон худалдааны байгууллагад ажилладаг. Гэтэл хязгаарлалтаас болж эдгээр байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосон нь тэдгээрийн өрхийн орлогод сөргөөр нөлөөлсөн байна.
- ii) Түүнчлэн эрэгтэйчүүдийн олонх нь барилгын салбарт ажилладаг бөгөөд хил хаагдаж, Хятад улсаас импортоор орж ирдэг зарим барилгын материал саатсанаас үүдэлтэйгээр оргил үедээ ажиллаж байх ёстой бизнес нь зогссон. Ийм хямралын улмаас ажилгүй гэртээ сууж, орлогогүй болсон нь гэр бүл дэх бухимдал стрессийг нэмэгдүүлсэн байна.
- iii) Малчдын хувьд орлого нь зөвхөн мал аж ахуйгаас хамааралтай тул хөл хорионы улмаас ноос ноолуурын үнэ ханш унаж, малчид банкны өрөнд орж, амьжиргаанд нөлөөлснөөр гэр бүлд санхүүгээс үүдэлтэй стресс бухимдал бий болсон байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 1

Ихэнх эмэгтэйчүүд голдуу үйлчилгээний байгууллагад ажилладаг. Хөл хорионы үед үйлчилгээний байгууллагууд ажиллахгүй байгаа болохоор гэр бүлд нь санхүүгийн асуудал үүссэн байдаг.

НЦҮТ-ийн эрх зүйч

Гүнзгийрүүлсэн ярилцлага 2

Би барилгын ажил хийдэг. Урдаас барилгын материал орж ирэхгүй хүлээгдээд ажил эхлэхгүй байгаа. Уг нь өдийд ажил эхэлчихсэн завгүй байдаг юм. Гэртээ суугаад байхаар гэрийн санхүү их хэцүү байна. Нэг хүний цалин амьдралд хүрэлцэхгүй. Гэртээ ингээд удаан байсан чинь их бухимдуу болох шинжтэй.

ГБХ-ийн зөрчил үйлдэн баривчлагдсан этгээд

Гүнзгийрүүлсэн ярилцлага 3

Бид ноолуурын үнэ өснө гэсэн хүлээлттэйгээр банкнаас хүүтэй зээл авчихсан байсан боловч хөл хорионы улмаас ноос ноолуурын үнэ унасан. Эхнэр бид хоёр санхүүгийн асуудлаас болж муудалцсан.

ГБХ-ийн зөрчил үйлдэн баривчлагдсан этгээд

Коронавирусын хөл хорионы үед төрөөс жирэмсэн болон 0-12 насны хүүхэдтэй ээжүүдийг гэрээсээ ажиллах нөхцөл боломжоор хангасан. Ийнхүү эмэгтэйчүүдэд бага насны хүүхдээ асран халамжилж, гэрийн ажлаа хийхийн зэрэгцээ гэрээсээ ажилласнаар ачаалал нэмэгдэж буй нь гэр бүлд стресс дарамтыг бий болгож, гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлсөн байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 4

Нөхрийн жижиг сажиг маргааныг ажилтай байх үед нээх юм санахгүй тэгээхийгээд мартчихдаг юм байна. Одоо харин гэртээ ингээд байгаад байхаар дарамттай, үнэхээр хэцүү байна.

НЦҮТ-ийн үйлчлүүлэгч эмэгтэй

Дээрх шийдвэрт зөвхөн эмэгтэйчүүд хамрагдсан бөгөөд өрх толгойлсон ганц бие аав нар үүнд хамрагдаагүй. Улсын хэмжээнд 19,468 өрх толгойлсон эрэгтэйчүүд байдаг.¹ Гэтэл тэд энэхүү шийдвэрт хамрагдаагүйгээс бага насны хүүхдүүд гэртээ харах хүнгүй үлдэх, улмаар үүдэн ахуйн хүрээний гэмтэл бэртэлд өртөх эрсдэлтэй байна.

Хөл хорионы улмаас гэртээ удаан байснаас гэр бүлийн өдөр тутмын хэвийн дэглэм алдагдаж, хосуудын харилцаанд зарим саад бэрхшээл, үл ойлголцол үүсэх болсон бөгөөд ихэнхдээ үүнийгээ ойлгож илэрхийлж чадахгүй, хэрхэн стресс бухимдлаа тайлахаа мэдэхгүй байгаа нь гэр бүлийн зөрчил маргаанд хүргэж байна. Уул уурхайд ажилладаг хүмүүсийн ажил хөл хорионы улмаас зогсож гэртээ суух болсон нь санхүүгийн хүндрэлээс үүдэлтэй бухимдал стрессийг нэмэгдүүлж гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлж байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 5

Уул уурхайд ажилладаг хүмүүс олноор цалингүй амралт авч байна. Тэд гэр бүлээсээ удаан хугацаанд тусдаа байсан болоод тэр үү, гэр бүлийхэнтэйгээ дасан зохицож чадахгүй зөрчилдөж эхнэр, хүүхэддээ гар хүрсэн тохиолдол байна.

НЦҮТ-ийн нийгмийн ажилтан

COVID 19 цар тахлын үед цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа хаагдаж, хүүхдүүд гэрээсээ суралцаж хичээллэх болсон. Ийнхүү тэд теле хичээл үзэж эхэлснээр эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдүүдийн хичээлийг нь давтуулах, хийлгэхдээ мэдлэг, ур чадвар дутмаг байдлаас болж бухимдах, уурлах зэрэг асуудал үүсгэж байгаа нь гэр бүлийн маргаан зөрчилд нөлөөлж байна.

ГБХ-ийн хохирогч (14 хүний 10 нь буюу 71%) болон ГБХ үйлдэгчид (10 хүний 5 нь буюу 50%) нь үзэж буйгаар ГБХ-д өртсөн хүүхдийн тоо нэмэгдэхэд хүүхдээс үүдэлтэй эхнэр, нөхөр хоорондын маргаан нөлөөлсөн байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 6

¹ www.1212.mn

Зурагтын хичээлийн даалгаврыг хийлгэх нь гэр бүлийн маргааны сэдэв болж байна. Бид хичээлийг нь ойлгохгүй юм. Тэгээд л хичээл хийлгэх, хийлгэхгүй, хийж чадах чадахгүйгээс болоод гэр бүлийн маргаан зөрчил үүссэн.

НЦҮТ-ийн үйлчлүүлэгч эмэгтэй

Гүнзгийрүүлсэн ярилцлага 7

Хүүхэд зурагтын хичээлийг ойлгохгүй хэцүү байхад нь манай нөхөр сувгуудыг тогтоож үзэхгүй хурдан хурдан сольдог. Хүүхдүүдийг дургүйцэхээр шоглодог. Хүүхдэд байнгын айдастай, гачигдалтай байх нь сүүлийн үед илт мэдэгдэх болсон.


ТХБ-нд үйлчүүлж буй хохирогч эмэгтэй

Гүнзгийрүүлсэн ярилцлага 8

Аав нь урьд өмнө амралтаараа ирэхдээ хүүхдийнхээ хичээлд анхаардаггүй, гэртээ байх үедээ голдуу ТВ үзээд байж байдаг байсан бол теле хичээл ордог болсноор хүүхдийнхээ хичээлд анхаарч хичээлийг нь хийлгэх гээд хүүхдээ зодсон тохиолдол байна.

НЦҮТ-ийн нийгмийн ажилтан

Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд гэртээ хөл хорионд орсноос болж Хүүхдийн тусламжийн утас 108-д ирэх дуудлагын төрөлд зарим өөрчлөлт гарсан байна. Тухайлбал хүүхдийн үе тэнгийн харилцаа, үерхэл нөхөрлөлийн талаар зөвлөгөө мэдээлэл хүссэн дуудлага 2020 оны эхний улиралд 162 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 59.3 хувиар буурсан байхад, гэр бүлийн харилцааны талаар зөвлөгөө хүссэн дуудлагын тоо 2020 оны эхний улиралд 499 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 56.4 хувиар нэмэгдсэн (Зураг 1) байна. Хүүхдүүд гэрээсээ хичээллэх болсноор гэр бүлийн харилцааны зөвлөгөө мэдээллийг илүү их хүсэх болсон нь харагдаж байна. Мөн хөл хорионы эхэн үед теле хэрхэн хичээлийг ойлгох вэ гэж зөвлөгөө мэдээлэл хүссэн хандалтын дуудлага их байсан байна.




Гүнзгийрүүлсэн ярилцлага 9

Энэ хөл хорионы үед хүүхдүүд байнга гэртээ байгаа. Хүүхдүүдийн хооронд байнга л асуудал гарна. Том хүү маань бага дүүгээ байн байн шоглоод уйлуулчихаад байхаар нь би тэсэлгүй хүүдээ гар хүрчихдэг юм. Үүнээс болоод эхнэр бид хоёр муудалцсан.

ГБХ-ийн зөрчил үйлдэн баривчлагдсан этгээд

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн хүүхдийн тоо 2020 оны эхний улиралд 30 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.1 дахин нэмэгдсэн (Зураг 2). Хүүхдүүд байнга гэртээ байх болсноор ГБХ-д өртөх нь нэмэгдэж байна.



Гүнзгийрүүлсэн ярилцлага 10

Манай дээр ГБХ-ийн улмаас охиноо алдсан ээж ирж үйлчлүүлсэн. Охин нь дотуур байранд амьдардаг байсан бөгөөд хөл хорионы улмаас хичээл орохгүй болж, гэртээ байх үедээ хойд эцгийнхээ гарт амиа алдсан.

НЦҮТ-ийн эрх зүйч

COVID 19 цар тахлын үед хөл хорионы улмаас баар, ресторан болон олон нийтийн үйлчилгээний газруудын үйл ажиллагаа зогссоноос ахуйн хүрээний архидалт ихээр нэмэгдсэн байна. Ийнхүү гэр орон, ах дүү, найз нөхдийндөө архидах болсноор гэр бүлийн хүчирхийлэл, тэр дундаа хүүхдийг үл хайхрах байдалд хүргэж байна.


Гүнзгийрүүлсэн ярилцлага 11

Хөл хорионы үед ахуйн хүрээний архидалт нэмэгдсэн нь тодорхой байна.

НЦҮТ-ийн нийгмийн ажилтан

Гүнзгийрүүлсэн ярилцлага 12

Ахуйн хүрээний архидалтын улмаас ээж нар өөрсдөө 108-д дуудлагаа өгч хүүхдүүдээ тэнд орхих тохиолдол байна. Энэ бол хүүхдийг үл хайхарч буй хүчирхийллийн хэлбэр юм.



2019 оны эхний улиралд гэр бүлийн хүчирхийллийн улмаас нийт гэмт хэрэг үйлдсэн иргэдийн 56.3 хувь нь согтуугаар үйлдсэн бол 2020 оны эхний улиралд 61.8 хувь нь согтуугаар үйлдсэн буюу согтуугаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх нь 5.5 нэгжээр өссөн байна (Зураг 3).

COVID 19 цар тахлын улмаас хүчирхийлэгчийн байнгын хараа хяналтад байх болсноор хохирогчдын нөхцөл байдал урт хугацаанд архаг шинжтэй болж хүчирхийлэл улам даамжирч, тэр хэмжээгээр өөрийгөө хамгаалах боломж нь багассан байна. ГБХ нь хохирогчид ямар нэг байдлаар сургууль, ажил, эмнэлгийн байгууллагуудад очсоноор мэдээлэгддэг байсан бол хөл хорионы улмаас далд хэлбэрт шилжиж байна. Тиймээс ийм хүчирхийллийн орчныг орхин зугтаан гарч ирсэн хохирогчдод НЦҮТ болон ТХБ-ны үйлчилгээний бэлэн байдал ямагт чухал байна.


Үнэлгээний НЦҮТ-өөр үйлчлүүлэгчдийн тоо 2020 оны эхний улирлын байдлаар 983 болж өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 88.7 хувиар өссөн байна.



Үйлчлүүлэгчдийн тоо эрс өссөн газруудыг нэг бүрчлэн тодорхойлоход:

1. Хөвсгөл аймаг дахь НЦҮТөв нь 2019 оны 2-р сараас 10-р сар хүртэл үйл ажиллагааны цар хүрээгээ багасган үйлчлүүлэгчдийг байрлуулахгүйгээр зөвхөн зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагаа явуулсан учир 2019 оны 3-р сард үйлчлүүлэгчийн тоо нэмэгдээгүй бөгөөд энэ нь 2020 оны тооноос харьцангуй бага харагдахад нөлөөлсөн гэж үзсэн. Өөрөөр хэлбэл энэ онд 183 болж өссөн нь COVID 19-ийн нөлөөнөөс хамааралтай гэж тус НЦҮТ-ийн зохицуулагч тайлбарласан.
2. Дархан-Уул аймаг дахь НЦҮТ-өөс өгсөн тоон мэдээллээ дахин нягталж засвар хийснээр 2020 оны эхний улиралд үйлчлүүлсэн иргэдийн тоо 46 болж багассан. Өөрөөр хэлбэл өмнө өгсөн 83 гэсэн тоо нь алдаатай байснаа хүлээн зөвшөөрсөн.
3. БЗД дэх НЦҮТ-ийн зохицуулагчийн хэлснээр тус төв нь 2019 оны 4-р сараас үйл ажиллагаа эхлүүлсэн ба өмнөх саруудтай харьцуулахад энэ оны эхний 3 сард огцом өсөлт байхгүй бөгөөд дээр өгөгдсөн тоо (72) нь алдаатай байж болзошгүй дахин нягтлах саналыг ирүүлж статистик мэдээгээ шинэчлэн ирүүлснээр эхний улиралд нийт үйлчлүүлсэн иргэдийн тоо нь 47 болж буурсан.

Дээрх тоон мэдээллээс харахад хамгийн их өсөлттэй байгаа ГССҮТ дэх нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн иргэдийн тоог өмнөх оны 1-р улиралтай харьцуулбал үйлчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн тоонд төдийлэн өөрчлөлт гараагүй боловч 18-35 насны иргэдийн тоо ойролцоогоор 2 дахин, 36 ба түүнээс дээш насны иргэдийн тоо ойролцоогоор 3 дахин нэмэгдсэн байна (Зураг 5).




Ийнхүү нэмэгдсэн шалтгаан нөхцлийг тодруулахаар тус төвийн ажилтнууд болон үйлчлүүлж буй хохирогчтой ярилцлага хийсэн. Ахуйн архидалт нэмэгдсэн гэдэг нь тус төвөөр хөл хорионы үед үйлчлүүлж буй хохирогчдын байдлаас ажиглагдсаныг эмнэлгийн ажилтнуудын яриа баталсан. Эдгээр хохирогчид ихэнх тохиолдол архинаас хамааралтайгаар гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн байх бөгөөд цөөнгүй нь нөхөртэйгээ хамтдаа архи согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдол гарсан. Ярилцлагад хамрагдсан нэг хохирогч нь мөн нөхөртэйгээ хамтдаа архидан согтуурсан үедээ марган хүчирхийлэлд өртсөн байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 13

...бага охин халуун тогоонд түлэгдэж, охиноо сахиад эмнэлэгт сар гаруй болчихоод гарсан. Тэгээд нөхөр, нөхрийн эгч дүү нартай цэргийн баяр тэмдэглээд хамт уусан.

НЦҮТ-өөр үйлчлүүлж буй хохирогч эмэгтэй



Түүнчлэн улсын хэмжээнд 2020 оны эхний улирлын байдлаар ГБХ-ийн улмаас баривчлах шийтгэл хүлээлгэсэн хэргийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулбал 98.7 хувь өссөн байна (Зураг 6).

Энэ нь хохирогчид НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлэх тоог буурахад нөлөөлсөн байх магадлалтай. Учир нь цагдаагийн албан хаагч хохирогчид Аюулын зэргийн үнэлгээ хийсний дараа, өндөр эрсдэлтэй тохиолдолд хохирогчдыг ТХБ-д авдаг. Харин хүчирхийлэл үйлдэгчийг даруйхан баривчилсан бол хохирогчийн эрсдэлт байдал буурч, гэртээ үлдэх боломжтой.


Гүнзгийрүүлсэн ярилцлага 14

Хамтран амьдрагчийг цагдаа эрүүлжүүлэх рүү авч явсаны дараа, бараг анх удаа 2 охинтойгоо гэртээ сайхан амарсан.

ТХБ-нд үйлчлүүлж буй хохирогч эмэгтэй

Олон нийтийн дундах хэвшмэл үзэл, тогтсон хандлага нь ГБХ-ийн хохирогчдийг НЦҮТ болон ТХБ-аар үйлчлүүлэхэд саад бэрхшээл болсоор байгаа нь COVID 19 цар тахлын үед ч мөн адил ажиглагдаж байна. COVID 19 цар тахлын улмаас дэлхийн улс орнуудад нийгэм эдийн засгийн хямрал бий болж, иргэдийн амьдралын ердийн хэв маягт өөрчлөлт орсноор гэр бүлийн харилцаанд бухимдал, зөрчил үүссэний улмаас ГБХ-ийн хохирогчдын тоо нэмэгдэх магадлал өндөр байна. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын 107 утсанд хандсан дүн мэдээнээс харахад энэ оны эхний улирлын байдлаар гэр бүлийн харилцааны зөвлөгөө мэдээлэл авах хүсэлтэй иргэдийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өндөр хувьтай байна (Зураг 7).

Тус төвд 2020 оны эхний улиралд нийт 673 хүн хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл авахаар хандсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 195-аар буюу 40.8 хувиар өссөн.



ГБХ-д шинээр өртөж буй иргэд хэнд хэрхэн хандахаа мэдэхгүйгээс гадна НЦҮТ болон ТХБ байрны талаарх тэдний мэдлэг хомс, үйлчилгээний аюулгүй байдал болон үйлчлүүлэгчийн нууцлалыг хадгалах эсэхэд эргэлздэг, үйлчилгээнд хамрагдсаны дараа хүчирхийлэгчийн зүгээс ирэх дарамт, шахалтаас айж эмээх, эсвэл гэр бүлийнхээ нэр хүндийг гутаахаас болгоомжлох зэргээс шалтгаалан үйлчилгээнд хамрагдаж чадахгүй тохиолдол байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 15

Би орон нутагтаа тодорхой эрх бүхий албан тушаалтан хэрнээ ГБХ-ийн талаар мэдээлэлгүй байсан. Өөрөө ГБХ-ийн хохирогч гэдгээ ч мэдээгүй 14 жил амьдарсан байна. Хамгийн сүүлд танигдахгүй болтлоо зодуулсан. Тэгээд шүүх шинжилгээний албанаас энд ирсэн.

НЦҮТ-д үйлчүүлж буй хохирогч эмэгтэй

Гүнзгийрүүлсэн ярилцлага 16

Би 3 сард 107 руу ярьж зөвлөгөө авч байсан. Манай нөхөр 3 сараас ажилгүй болж архи уух нь ихэссэн. Тэгээд тухайн үед гэр бүлийн асуудлаа дэлгэхээс санаа зовоод ирээгүй.

ТХБ-нд үйлчүүлж буй хохирогч эмэгтэй

Гүнзгийрүүлсэн ярилцлага 17

ГБХ-ийн улмаас хохирсон хүнийг хамгаалдаг ийм сайхан газар, үйлчилгээ байдгийг би ерөөсөө мэддэггүй байсан. Улс орон минь хөгжиж байна.

ТХБ-нд үйлчүүлж буй хохирогч эмэгтэй

Гүнзгийрүүлсэн ярилцлага 18


Манай нөхөр эрүүлжүүлэхээс гарсан өдрөө архи ууж ирээд “намайг эрүүлжүүлэхэд өгч баривчлуулдаг чи хэн?” гээд цохиж зодоод, боож унагасан.

ТХБ-нд үйлчүүлж буй хохирогч эмэгтэй

Гүнзгийрүүлсэн ярилцлага 19

Нэг талаас хүмүүс хуулиа мэддэг болсон. Нөгөө талаар хүчирхийлэл үйлдэгчдийн арга нь нарийсч бие махбодийн хүчирхийллээс илүүтэй сэтгэл санаа, эдийн засгийн хүчирхийллийг хохирогчдод үзүүлэх болсон. Гэтэл эдгээрийг нь баримтжуулахад төвөгтэй байдаг. Тиймээс иргэдээс хуулиа эргэж хараач гэсэн гомдол ирж байгаа.

НЦҮТ-ийн сэтгэл зүйч



ЦЕГ-ын тоон мэдээнд 2020 оны эхний улирлын байдлаар ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61.8 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь олон нийт, мэргэжлийн байгууллагуудын анхаарлыг ихээхэн татсан. Иймээс судлаачдын зүгээс дээрх өсөлтийн учир шалтгааныг тодорхойлохын тулд тоон мэдээг өргөжүүлж 2019 оны 1-р сараас 2020 оны 3-р сар дуусталх тоо мэдээнд дүн шинжилгээ хийсэн.

Сүүлийн нэг жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн бүртгэгдсэн зөрчлийн тоо аажмаар өссөн үзүүлэлттэй байгааг Зураг 8-аас харж болно. Энэ нь сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийллийн талаарх олон нийтийн мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх олон талт арга хэмжээг төрийн байгууллагууд донор байгууллагын дэмжлэгтэйгээр тасралтгүй авч хэрэгжүүлсэн. Үр дүнд нь ГБХ-ийн зөрчлийн талаар дуудлага мэдээлэл өгөх явдал нэмэгдсэн бөгөөд цагдаагийн байгууллагаас энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлж, зөрчлийн шатанд нь илрүүлэх арга хэмжээ авдаг болсон нь ийнхүү

бүртгэгдсэн зөрчлийн тоо нэмэгдэхэд нөлөөлсөн² байна. Энэ нь ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо буурахад нөлөөлсөн.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 20

ГБХ-ээс урьдчилан сэргийлэх аянуудыг, сүүлд “Ойлгоё, хүндэлье” аяныг зохион байгуулснаар гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн тоо нэмэгдэхэд нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл хүмүүсийн мэдлэг нэмэгдэж, ЦЕГ аяны хүрээнд энэ төрлийн хүчирхийллийг гэмт хэрэг болохоос нь өмнө илрүүлдэг болсноор зөрчлийн тоо нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа. Мөн ГБХ-ийн хохирогч, холбогдогчийн тоо өссөн нь тоон мэдээг шивэхдээ хохирогч, холбогдогчдыг ГБХ-тэй холбоотой эсэхийг тодруулж шивдэг болсон Цагдаагийн газрын бодлоготой холбоотой юм.


Цагдаагийн албан хаагч

Гүнзгийрүүлсэн ярилцлага 21

Урьдчилан сэргийлэх аяны хүрээнд баривчлагдсан хүмүүсийн тоо их нэмэгддэг. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн улмаас баривчлагдсан хүмүүсийн тоо ч үүнтэй адилаар аян зарлах үеэр нэмэгдээд байдаг.

Баривчлах төвийн ажилтан

Бид COVID 19 цар тахлын хөл хорионы үе дэх ГБХ-ийн өсөлтийн дүн мэдээг нягтлахын тулд зөвхөн 3-р саруудад харьцуулалт хийлээ. 2020 оны 3-р сард ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны 3-р сартай харьцуулахад 55.7 хувиар (Зураг 9), зөрчлийн тоо 86.8 хувиар (Зураг10) тус тус өссөн үзүүлэлттэй байгаа нь цар тахлын үед авч хэрэгжүүлж буй хөл хорионы арга хэмжээ ГБХ-д нөлөөлсөн байна.




² Хууль зүйн луужин нэвтрүүлэг, ЦЕГ-ын ГБХ-тэй тэмцэх хэлтсийн хошууч н.Мөнхсүвдын яриа <https://www.facebook.com/RPentertainmenttv/videos/294795834844282/>

Гүнзгийрүүлсэн ярилцлага 22

Манай байгууллагаар үйлчлүүлэгчдийн энэ оны (2020 он) эхний 4 сарын тоо өнгөрсөн он (2019)-д үйлчлүүлсэн нийт үйлчлүүлэгчийн тооноос хоёр дахин өссөн үзүүлэлттэй байна. Энэ өсөлт цах тахлын улмаас үүсээд буй нөхцөл байдалтай холбоотой.

НЦҮТ-ийн нийгмийн ажилтан



Үйлчилгээ үзүүлж буй НЦҮТ болон ТХБ-ын хувьд онцгой нөхцөл байдлын үед хэрхэн ажиллах, коронавирусын шинж тэмдэг бүхий үйлчлүүлэгч ирсэн тохиолдолд дэс дараалалтай арга хэмжээг хэрхэн авч үйлчилгээ үзүүлэх талаар тусгай дагаж мөрдөх журамгүй байгаагаас гадна ажилтан, албан хаагчид цар цахлын үед ажиллах сэтгэлзүйн бэлэн бус байдал үйлчилгээний чанарт нөлөөлж үйлчлүүлэгчдийн тоог бууруулсан байх магадлалтай. Гэсэн хэдий боловч НЦҮТ-үүдэд биеэр ирж зөвлөгөө авах, утсаар зөвлөгөө өгсөөр байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 23

Би бага насны хүүхэдтэй. Өөрөө мэдэхгүй байж байгаад вирус өвчин тусгаад гэртээ очихвий гэсэн айдастай ажиллаж байна.

НЦҮТ-ийн эмч

Гүнзгийрүүлсэн ярилцлага 24

Би эрүүл мэндийн байгууллагын ажилтан болохоор хөл хорионы үеийн хяналт шалгалт хийгээд ажлын шаардлагаар гадуур ажиллаж байсан юм. Нөхрийн ажил худалдааны байгууллага учраас ажиллахгүй гэртээ байсан. Над руу байнга утасдаж, ажил хийлгэхгүй хардаж, сэтгэл санааны дарамттай нөхцөлд ажлаа гүйцэтгэсээр байна.

НЦҮТ-ийн үйлчлүүлэгч эмэгтэй

Гүнзгийрүүлсэн ярилцлага 25

Хөл хорионы улмаас биеэр ирж зөвөлгөө авах нь багассан.

НЦҮТ-ийн сэтгэл зүйч

Гүнзгийрүүлсэн ярилцлага 26

Надад эндхийн ажилтан “Хүнд гэр орон л хэрэгтэй. Чи энд хүүхдүүдтэйгээ хоног төөрүүлж яваа юм уу? Ийм (хөл хорионы) үед гэртээ харьсан чинь дээр” гэж байсан.

НЦҮТ-д үйлчлүүлж буй хохирогч эмэгтэй

Онцгой нөхцөл байдлын үед ажилтан албан хаагчдын сэтгэл зүйн бэлэн байдал, ажлын чиг үүргийг тодорхой болгож, нарийвчилсан заавар зөвлөгөөг шуурхай өгч ажиллах хэрэгцээ байна. Түр хамгаалах байр болон баривчлах төв, НЦҮТ-ийн ажилтан албан хаагчдын халдвар хамгаалал, хувийн аюулгүй байдлыг дэмжин ажилласнаар ажлын байран дах сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхээс гадна үйлчлүүлэгчдэд хүрэх үйлчилгээний чанар нэмэгдэх нь гарцаагүй.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 27

Ажилтан албан хаагчдын сэтгэл зүйн бэлэн байдал, сэтгэл зүйн мэдээлэл өгөх тал дээр орхигдуулах тал байдаг.

Сэтгэл зүйч

Хөл хориотой холбогдуулан төрөөс авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ цар халын үед нэн тэргүүнд хамгаалалтад байх ёстой хохирогчийг хамгаалах үйлчилгээг шуурхай хүргэхэд зарим саадыг учруулсан. НЦҮТ-үүдийн үйл ажиллагаа чухам ийм нөхцөлд тасралтгүй явагдаж байх ёстой боловч удирдах ажилтнуудын ойлголт хангалтгүйгээс үйл ажиллагаа доголдох явдал гарсан нь анхаарал татаж байна. Мөн зарим НЦҮТ-ийг цар тахлын үеийн тусгаарлах байрны зориулалтаар ашиглах шийдвэр гаргасан нь хохирогчийг хамгаалах үйлчилгээ тасалдах аюулыг бий болгож байгаа нь анхаарал татсан. Түүнчлэн эрх бүхий этгээд нь үйлчилгээний нууцлал, ёс зүйг үл хайхран үйлчлүүлэгч (хохирогч)-ийн зургийг олон нийтийн сүлжээнд байршуулсан тохиолдол байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 28

... аймгийн Засаг дарга Түр хамгаалах байрыг тусгаарлах байр болгох чиг өгсөн байсан.

Мэргэжилтэн

Гүнзгийрүүлсэн ярилцлага 29

... орон нутгийн удирдлагууд НЦҮТ-ийн үндсэн зорилгыг сайн ойлгоогүйгээс захирамж гарган хөл хорионы үед ТХБ-ыг 21 хоног тусгаарлах байр болгон ашигласан. Бидний үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байх ёстой. Гэтэл бид тэмцээд дийлэлгүй, харанхуй шөнө 10 үйлчлүүлэгч (1 том хүн, 9 хүүхэд)-ээ аваад тэдний зааж өгсөн ямар ч халдваргүйжилт, ариутгал хийгдээгүй байранд ирсэн. Нүүлгэн шилжүүлэлтийн үед хүүхдүүд сэтгэл санаагаар унаад хэцүү байсан.

НЦҮТ-ийн ахлах мэргэжилтэн

Гүнзгийрүүлсэн ярилцлага 30

... гэнэтийн нүүлгэн шилжүүлэлтийн үед үйлчлүүлэгчид сэтгэл санаагаар унаад хэцүү байсан.

НЦҮТ-ийн сэтгэл зүйч

Гүнзгийрүүлсэн ярилцлага 31

... дарга үйлчилгээний нууцлалд хайнга хандаж байгууллагын гаднах зураг, манай ажилтны үйлчилгээ үзүүлж буй зураг, тэр ч байтугай хохирогчийн зургийг өөрийн фейсбүүктээ оруулсан нь үйлчлүүлэгчийн итгэлийг алдах, үйлчилгээний аюулгүй байдалд бэрхшээл учруулахаар байна.

НЦҮТ-ийн нийгмийн ажилтан

Засгийн газар, яам агентлаг, нийслэл болон улсын онцгой комисс зэрэг байгууллагаас онцгой нөхцөл байдлын үед авч хэрэгжүүлж буй шийдвэр, арга хэмжээ нь ард иргэдийг цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад хувь нэмэр оруулсаар байна. Гэвч зарим гэнэтийн шийдвэр гаргахад жендерийн мэдрэмжтэй байдлыг харгалзан үзэх, олон нийтийн санал бодол буюу үнэлгээнд тулгуурлах хэрэгцээ байна.

Тухайлбал Монгол улсад COVID 19 цар тахлын анхны тохиолдол албан ёсоор зарлаж, хөл хориог чангатгасан үед төрийн үйлчилгээний цахим машин (ТҮЦ машин)-ны үйл ажиллагааг зарим байршилд түр хугацаагаар зогсоосноос ТҮЦ машин ажиллаж буй цөөхөн байрлалд хэт ачаалал нэмэгдэж хүмүүсийн бөөгнөрөл үүсгэж, халдварт өвчин авч болзошгүй эрсдэл бүрдүүлснээс гадна хохирогчийг яаралтай хамгаалалтад авахад хугацаа алдахад нөлөөлсөн. Хохирогчийг яаралтай хамгаалалтад авч үйлчилгээ үзүүлэхэд тухайн иргэний бичиг баримт нэн шаардлагатай тул хохирогч иргэний лавлагаа мэдээлэл авахын тулд ТҮЦ машин ашиглах нь үйлчилгээг хурдан шуурхай хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 32

Ковидын анхны тохиолдол бүртгэгдсэн үед бид ажиллаж байгаа ТҮЦ машин олох гэж хоёр өдөр болсон. Хамгаалах байраар бичиг баримтгүй хүмүүс их ирдэг. Тэднийг бичиг баримтжуулж байж эрх зүйн үйлчилгээг үзүүлж чадна. Бид ТҮЦ машин яагаад ажиллахгүй байгааг холбогдох байгууллагаас тодруулахад ковидын үед олон хүн нэг дор цуглуулахгүйн

тулд ихэнх ТҮЦ машинаа хаачихсан байсан. ТҮЦ ажиллаж байгаа цэгүүд дээр очиход эсрэгээрээ хэт их хүмүүс овоорчихсон, урт дараалал үүсчихсэн байсан. Бид хуулийн тодорхой хугацаанд асуудлыг шийдвэрлүүлэх ёстой. Гэтэл хөл хорионы үед үүнийг зохицуулах зохицуулалт байхгүй байна.

НЦҮТ-ийн эрх зүйч

Амь насаа эрсдэлд оруулахгүйн тулд хүчирхийллийн орчин болон хүчирхийлэгчээс зугтаан гарч ирсэн хохирогчийг давхар эрсдэлд оруулах, улмаар нэн түрүүнд үзүүлэх ёстой үйлчилгээнд аль болох хурдан хамруулахад дээрх арга хэмжээ сөргөөр нөлөөлөх тал ажиглагдаж байлаа. Хохирогч аливаа үйлчилгээг ялангуяа эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай авахад бэрхшээл учирсан тохиолдол байна.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах үйлчилгээнд салбар дундын хамтын ажиллагаа туйлын чухал юм. Гэвч хязгаарлалтын үед хохирогчийг хамгаалах, шаардагдах үйлчилгээг цаг алдалгүйгээр үзүүлэхэд үйлчилгээний байгууллагуудын хамтын ажиллагаагаа сул байгаа нь ажиглагдаж байлаа.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 33

Ковидын анхны тохиолдол илрээд байсан үед үйлчлүүлэгчээ аваад эмнэлгээр явахад амны хаалт зүүгээгүй байна гээд үйлчилгээ үзүүлэхгүй байсан. Тэр үед амны хаалт олдоц муу, үнэ хадсан, бүгд л айж түгшсэн байсан. Яг энэ үед цар тахлаас илүүтэй сэтгэл санааны дарамтаар нас барахаар юм байна гэж бодогдсон.

НЦҮТ-ийн эмч

Гүнзгийрүүлсэн ярилцлага 34

Засгийн газар хүүхэд хамгааллын зардлыг татсан байгаа.

Мэргэжилтэн

Одоогоор хөдөө орон нутгийн хувьд зөвхөн аймгийн төвүүдэд хохирогчийг хамгаалах үйлчилгээ байрлаж байна. Аймгийн төв рүү орох гарах хөдөлгөөний хязгаарлалт тогтоосноор сум, орон нутгаас хохирогч үйлчилгээ авахаар ирэх үед хот суурин газарт ямар журмаар нэвтрэн орох талаар нэгдсэн зохицуулалт гараагүй байна. Сумын цагдаагийн хэлтсээс тодорхойлолт авч нэвтэрсэн тохиолдол байгаа боловч яаралтай үед энэ нь хохирогчийг хамгаалахад саад бэрхшээл учруулж болзошгүй байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 35

Аймаг руу орох гарах хөдөлгөөнийг хориглосон үед хөдөөнөөс нэг эмэгтэй нөхрөөсөө зугтааж манай НЦҮТ-д хамгаалуулахаар аймгийн төв рүү орж ирэхдээ сумын цагдаагийн бичгээ үзүүлж байж орж ирсэн байсан. Сумынхаа цагдаагаас бичиг аваагүй шууд ирсэн бол оруулах байсан үгүйг хэлж мэдэхгүй байна.

НЦҮТ болон ТХБ-ын үйл ажиллагааны зардал болон санхүүжилтийн эх үүсвэрийг төрөөс хариуцах ёстой боловч тэр бүр хэрэгжихгүй байгаа нь үйлчилгээний чанар хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгох, цар тахлын дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, халдварт өвчин гарсан үед авах арга хэмжээтэй холбоотой нэмэлт зардал гарах үед хэрхэн санхүүжүүлэх зохицуулалт байхгүй. Норм нормативт зардал нь зөвхөн тогтмол явагдах үйл ажиллагаанд зарцуулагдахаар төлөвлөгдсөн байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 36

Нэгэнт л үйлчилгээ үзүүлж байгаа бол ТХБ-нд хүн амьдрахад хэрэгтэй бүхий л зардлыг улс гаргах ёстой. Төсөвгүй учраас иргэд улсын ачааг үүрээд хандив тусламж үзүүлээд байна. Холбогдох яам, шийдвэр гаргагчид түрүүлж ажиллаж чадахгүй байна. Ариутгал, хамгаалалтад нэмэлтээр шаардагдах бодис материалуудыг хангалтаар өгсөн, тэгснээс биш үүнтэй холбоотой нэмэлт зардлын төсөв байхгүй.

Удирдах ажилтан

Хязгаарлалтын дэглэмд шилжсэнтэй холбогдуулан зарим байгууллагын ажилтан албан хаагчид уртасгасан цагаар ажиллах хэрэгцээ шаардлага гарсан. Онцгой нөхцөл байдлын үед НЦҮТ болон ТХБ-нд ажиллаж буй ажилтан, албан хаагчдийн илүү цагаар ажилласан цалин хөлсийг тооцдог нэмэлт зохицуулалт байхгүй.

Түүнчлэн хохирогчдод үзүүлэх хоол хүнсний нөөц, норм нормативийг шинэчилж батлаагүй, хүлээлттэй байгааг анхаарч үзэх хэрэгтэй. Энэхүү хувьсах зардлын нормативд онцгой нөхцөл байдлын үед зарцуулах төсвийн уян хатан зохицуулалт байхгүй байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 37

Ковидтой холбоотойгоор бид өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгтэй ажиллаж байгаа. Мөн зарим ажилтнууд нэмэлт цалингүйгээр уртасгасан цагаар ажилласан.

Удирдах ажилтан

Эцэг эх, асран хамгаалагчдын хараа хяналт сул, ядуурлын түвшин өндөр байгаагаас шалтгаалан гадуур тэнүүлэн амьдарч буй насанд хүрээгүй хүүхдүүдийг ТХБ-нд хамгаалтанд авч үйлчлэх тохиолдол түгээмэл байна. Сургууль, цэцэрлэгийн хоол хүнснээс хамааралтай байсан хүүхдүүдийн хувьд хамгаалах байранд байхыг илүүд үзсэн, мөн эцэг эх нь архи дан согтуурахын тулд зориудаар хүүхдээ хамгаалах байранд дуудлага өгч байрлуулах явдал байгаа талаар Хүүхдийн тусламжийн утас 108-ын дэргэдэх түр хамгаалах байрны ажилтнууд дурдсан.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 38

*Хүүхдүүд гэртээ байхаар их өлсөж байна. Сургуулийн хоол байхгүй.
Хамгаалах байранд ирж байгаа хүүхдүүд их өлмүүн зэлмүүн байна.*

НЦҮТ-ийн нийгмийн ажилтан

Гүнзгийрүүлсэн ярилцлага 39

*Архидан согтуурахын тулд хүүхдээ 108-д дуудлага өгч, хараа хяналтгүй
гэдгээр хамгаалах байранд байрлуулах тохиолдол гарсан.*

Удирдах ажилтан

Гүнзгийрүүлсэн ярилцлага 40

*Хөл хорионы улмаас дотуур байрын хүүхдүүд гэртээ байх болсон. Ээж нар
нь хүүхдүүдийнхээ дэргэд архи ууж чадахгүй болсондоо уурлаж хүүхдээ
зодох, хөөж туух зэргээр сэтгэл санаа, бие махбодийн хүчирхийлэл үзүүлэх
нь нэмэгдсэн.*

НЦҮТ-ийн сэтгэл зүйч

Хөл хорионы дэглэмийн үед иргэдийг олноор цуглуулсан сургалт уулзалтыг хориглосон нь баривчлах төвийн үйл ажиллагаанд ч мөрдөгдөж байна. Тус төвд гэр бүлийн хүчирхийллийн улмаас баривчлагдан шийтгүүлж буй 600 гаруй иргэдэд зан үйлд нөлөөлөх ямар нэгэн танхимын сургалт хийгдээгүй байна. Өрөө бүрт байх зарлан мэдээллийн шугамаар мэдээлэл дамжуулах, өрөөнүүдэд байрлуулсан дэлгэцийг ашиглан сургалт явуулах талаар төлөвлөж байгаа нь давуу талтай байна.

Гүнзгийрүүлсэн ярилцлага 41

*Корона гарснаас хойш хүмүүсийг бөөгнүүлэхгүй гээд сургалт явуулахгүй
байгаа. Харин зарим өрөөнд суурилуулсан ТВ-ээр зөвлөгөө мэдээлэл өгч
ажиллаж байна.*

Баривчлах төвийн албан хаагч

Түргэвчилсэн үнэлгээний явцад хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр онцгой нөхцөл байдал дах ЖСХ/ГБХ - ийн талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн бөгөөд ихэнхи тохиодолд олон нийтийг төөрөгдүүлсэн ташаа мэдээлэл цацагдаж байгаа нь ажиглагдаж байлаа. Төрийн томоохон албан тушаал хашиж байсан болон одоо төрд ажиллаж буй мэргэжилтнүүдийн зүгээс яарч мэдэгдэл хийх, дүн шинжилгээ хийж нягтлаагүй тоон мэдээлэлд тулгуурлан олон нийтэд мэдээлэл өгөх зэрэг үзэгдэл гарч байгаа нь ард иргэдийн үнэн зөв мэдээллийн хүлээн авахад саад болж, төөрөгдөлд оруулах талтай байна.



Жишээ нь, ГБХЗХГ-аас цахим хуудастаа “[Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн тоо сүүлийн 3 сарын хугацаанд 217.4 хувиар өслөө](#)” гэх мэдээллийг нийтэлсэн байна.

Энэхүү тоо мэдээг ЦЕГ-ын тоон мэдээнд тулгуурлан тооцоолсон байсан. Гэвч тус статистик мэдээлэл нь нэмэгдсэн дүнгээр гардаг тул 3-р сард гарсан тоо нь эхний 3 сарын нийлбэр гэдгийг дутуу шинжилсний үндсэн дээр ийм мэдээллийг гаргасан байна. Тус тоон мэдээгээр 1-р сард 86, 2-р сард 160, 3-р сард 273 болж нэмэгдсэн ба зөвхөн 3-р сард хохирсон иргэдийн тоо 113 байна.

Дөрөв. ЗӨВЛӨМЖ

Үнэлгээний үр дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжүүдийг санал болгож байна:

ЖСХ/ГБХ – ийн хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр бодлого, журам боловсруулах, шийдвэр гаргах

- Онцгой нөхцөл байдлын үед хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай үед хохирогчийг хамгаалах орон байр, боловсрол, хоол тэжээл, ариун цэвэр, зам тээврийн үйлчилгээг тасалдуулахгүй хүргэх чиглэлээр холбогдох чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаанд үндэслэсэн хөл хорионы үед хэрхэн хамтран ажиллах тогтолцоог бий болгож, бодлого журам боловсруулан мөрдөх ажиллах ба үүнд Хохирогч-төвтэй зарчим баримтлах
- НЦҮТ болон ТХБ зэрэг гэр бүлийн хүчирхийллийн хохирогч иргэдийг түр хамгаалалтанд авч аюулгүй байдлыг ханган ажилладаг үйлчилгээний байгууллагууд цар тахлын үед яаралтай тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө, стратеги, зөвлөмж боловсруулан ажиллахдаа “**Нэг гэр бүлд нэг өрөө**” гэсэн зарчим баримтлах. Хохирогч, үйлчлүүлэгч хамгааллын бэлэн байдлын төлөвлөгөө, стратеги боловсруулах явцад мэргэжлийн зөвлөгөө, удирдлагаар тасралтгүй хангах

ЖИЧ: Өнөөдрийн байдлаар Монгол улсад хохирогчийг хамгаалах байрны багтаамж, хүчин чадлыг тооцохдоо гэр бүлийн хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүд ганцаараа ирдэггүй үр хүүхдүүдтэйгээ ирдэг байдлыг харгалзан үзэх шаардлагатай. Ихэнх үйлчлүүлэгч эмэгтэйчүүд 3 ба түүнээс дээш хүүхэдтэйгээ ирж үйчилгээ авч байна. Тиймээс хамгаалах байрын орны тоог нэг хүн биш нэг гэр бүлийн гишүүд нэг дор нэг өрөөнд байрлах байдлаар зохицуулах нь цар тахлын үед ч нэн хэрэгцээтэй, халдвар хамгаалалтыг сайжруулахад тустай.

- Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлага зохион байгуулалт, ажлын гүйцэтгэл-урамшууллын бодлого зэрэг байгууллагын үйл ажиллагааны цогц байдлыг хангасан “Онцгой нөхцөл байдалд ажиллах үйл ажиллагааны дотоод журам” баталж, төсөвт онцгой нөхцөл байдлын үед ажиллахтай холбогдох цалингийн болон бусад хувьсах зардлыг тусгаж мөрдөн ажиллах
- Хөл хорионы дэглэмийн үед хамтарсан багийн гишүүд, багш, нийгмийн ажилтны ажил үүргийн хуваарийг хүүхэд, гэр бүл хамгааллын ажил үүрэгтэй уялдуулан гэр бүлийн хүчирхийллийг мэдээлэх, илрүүлэхэд нэмэлт зааварчилгаа өгч чиглүүлэн ажиллуулах, онөхцөл байдлын үед ЖСХ/ГБХ-ийн хохирогчид анхан шатны үйлчилгээ үзүүлэхэд эмч, эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааг бодлогын түвшинд улам сайжруулан нягтруулах
- ЖСХ/ГБХ –ийн чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагын хүний нөөц болон санхүүгийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд анхаарч онцгой нөхцөл байдалтай холбогдуулан гарч болох нэмэлт зардлуудыг санхүүжүүлэх. Тухайлбал ГБХЗХГ-ын шууд удирлагад харьяалагдах НЦҮТ-ийн ажилтнууд ихэнхдээ гэрээт ажилтнаар ажиллаж байна. Тэднийг институтчлан бүтцэд оруулж үндсэн ажилтан болгох хэрэгцээ байна. Учир нь Монгол улсад 2009 оноос хойш 11 жилийн хугацаанд нийт 17 НЦҮТ бий болсон байгаа нь ЖСХ/ГБХ-ийг таслан зогсоох, үүнээс урьдчилан сэргийлэхэд маш том ахиц дэвшил гарсан байна. Харин энэхүү

үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад тэргүүн шугамд зогсож буй НЦҮТ болон ТХБ-ын мэргэшсэн ажилтнуудын урсгал хөдөлгөөн, тогтвортой байдлыг хангахад хүний нөөцийн асуудлыг онцгойлон анхаарах хэрэгцээ байна.

- Онцгой нөхцөл байдлын үед гаргаж буй шийдвэрүүд нь аль болох жендерийн мэдрэмжтэй байх, улс төрөөс ангид байх, хохирогч-төвтэй эрх ашгийг нь харгалзан үзсэн байхад анхаарч хохирогчийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах
- Хамтарсан багийн үйл ажиллагаа болон үйл ажиллагаатай холбоотой зардал, төсвийг онцгой нөхцөл байдлын үед таналгүйгээр үргэлжлүүлэн олгохдоо мэргэжлийн удирдлагаар хангах
- Цар тахлын хөл хорионы арга хэмжээг авч хэрэгжүүлж буй үеийн ГБХ-ийн нөхцөл байдлын талаар үргэлжлүүлэн судлах, судалгаанд үндэслэсэн зохистой бодлого, шийдвэр, дүрэм журам боловсруулан ажиллаж, хэрэгжилтийг байнга үнэлж байх, үнэлгээг олон нийтэд мэдээлж байх
- ЖСХ/ГБХ-ын талаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж буй байгууллагуудын статистик мэдээлэл, тоо бүртгэл үнэн зөв хөтлөгдсөн эсэхэд анхаарал тавьж ажиллахаас гадна бүртгэлийн мэргэжилтэн болон байгууллагуудын мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх арга зүйг сайжруулахад ахиц дэвшил гаргаж ажиллах шаардлага байна.

Урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгаа нөлөөллийн ажил зохион байгуулах

- Хамтарсан багийн гишүүд, багш, нийгмийн ажилтан, хамгаалах байрны ажилтнууд төдийгүй хохирогч, хүчирхийлэл үйлдэгчдэд зориулсан цар тахлын үе бэлэн байдлын чадавхжуулах сургалтуудыг тасралтгүй зохион байгуулахад анхаарч, зайн болон сургалтын бусад арга хэрэгслүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- Сургалт сурталчилгаа мэдээллийн ажлыг малчид, орон нутгийн иргэдэд онцгой нөхцөл байдлын үед үр дүнтэйгээр тасралтгүй хүргэхэд анхаарч, техник технологийн дэвшлүүдийг ашиглах
- Хохирогч болон олон нийт, хөршийн зүгээс хүчирхийллийн дуудлагыг хүлээн авах боломжуудыг нэмэгдүүлэх, онлайн болон чатбот, мессэжээр дуудлага авах, зарим тохиолдолд хэрэглэх нууц үг кодчиллуудыг ашиглах зэрэг шинэлэг санаачилгыг дэмжин ажиллах
- Онцгой нөхцөл байдлын үед иргэд аав ээж, ах дүү нартайгаа утас болон бусад сошиал аппликейшн ашиглан холбогдох бололцоог дэмжин ажиллах. Онлайн зөвлөгөө, дуудлага өгөх, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх ба үүнд нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлах
- ЖСХ/ГБХ-ийн талаар мэдээллийн бүх хэрэгслийг ашиглан сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, сургалт явуулах багш нарын санаачилга, байгууллагын зүтгэлийг дэмжин ажиллах шаардлага байна.
- Албан ба албан бус боловсролоор дамжуулах гэр бүлийн боловсролыг өсвөр үе, хүүхэд залуучуудад олгох ажлыг дэмжих, идэвхжүүлэх. Гэр бүлийн боловсролыг ахлах ангиас нь хичээлийн хөтөлбөрт багтаан олгох

- ЖСХ/ГБХ, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хөршийн холбоог сайжруулах

Онцгой нөхцөл байдлын үед НЦҮТ, ТХБ болон БТ-ийн үйл ажиллагааг сайжруулах

- Онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгаалал, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмадын настны эрх ашгийг хамгаалахад чиглэсэн бэлэн байдлын төлөвлөгөө мөрдөн ажиллахаас гадна үйл ажиллагааны зардлыг төсөвт жил бүр тогтмол суулгаж хэвших
- Онцгой нөхцөл байдлын үед үйлчүүлэгч, хохирогч нарт үзүүлж буй үйлчилгээ, хамгааллын ажил нь товлосон хугацаанд, үр дүнтэй, чанартай хэрэгжилтэд анхааран дотоод болон хөндлөнгийн үнэлгээ хийх, зөвлөмж үр дүнг ийм нөхцөл байдал дахин тохиолдсон үед хэрэглэх боломжийг бүрдүүлэх
- НЦҮТ, ТХБ, БТ-ийн ажилтан, албан хаагчдад энэхүү онцгой нөхцөл байдлын үед хэрхэн ажиллах талаар сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулж, тэдний аюулгүй байдлыг байнга дэмжин ажиллах
- НЦҮТ, ТХБ болон БТ-ийн орчны эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтэд орон нутгаас төсөв санхүүгийн дэмжлэг үзүүлж хэвших
- Халдвартай хүн ирж үйлчлүүлсэн тохиолдолд хэрхэн ажиллах талаар журам, зааварчилгаа боловсруулан мөрдөх

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. НҮБХАС. Хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний тайлан. 2017.
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага. УБ. 2017
3. ХЗДХ-ийн Сайдын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/25 тоот тушаал. Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам.
4. ХЗДХ-ийн Сайдын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/38 тоот тушаал. НЦҮТ-ийн аюулгүй байдалд хяналт тавих журам.
5. ХНХЯ-ны сайдын 2017 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн А/73 тоот тушаал. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам.
6. ХНХЯ-ны сайдын 2017 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн А/74 тоот тушаал. Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журам.
7. ХЗДХ-ийн сайд, ХНХЯ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан ын 2017 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн А/63, А/48, А106 тоот хамтарсан тушаал. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын журам.
8. Улсын ерөнхий прокурор, ХЗДХ-ийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн хамтарсан тушаал. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлын хангах журам
9. Хөдөлмөр, халамжийн ерөнхий газрын даргын 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн тушаал. Аргачлал батлах тухай.

ХАВСРАЛТ 1

Оролцогчид	Ярилцлагын агуулга
<p>Шийдвэр гаргах түвшинд: ХНХЯ, ХЗДХЯ, ЭМЯ, БСШУЯ, ЦЕГ, ГХУСАЗЗ, ГБХЗХГ, ХЭҮК-ын мэргэжилтнүүд</p>	<ul style="list-style-type: none"> - ЖСХ/ГБХ улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн тоо өссөн, буурсан шалгааныг тодруулах - Энэхүү нөхцөл байдал нь онцгой байдлын үед авч хэрэгжүүлж буй хөл хорио тогтоосонтой холбоотой эсэх - Тулгамдаж буй асуудлын талаар тодруулах - Онцгой нөхцөл байдлын үед салбар дундын хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах талаарх санал бодол - Үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд одоогийн байгаа хүчин чадлынхаа хүрээнд шаардлагатай үйлчилгээг чанартай хүргэж буй эсэх - Хүний нөөцийн чадавх, боломж ба орон нутгийн нөөц бололцоо - Онцгой нөхцөл байдлын үед НЦҮТ болон хамгаалах байранд шаардлагатай санхүүгийн болон бусад нөөц боломж хангалттай буй эсэх - 2020 он дуустал үйл ажиллагаагаа тогтвортой, үр дүнтэй явуулахад хэрхэн ажиллах талаарх санал санаачлага - Онцгой байдлын үе дэх ЖСХ/ГБХ –ын хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд өгөх санал зөвлөмж - Онцгой нөхцөл байдлын үед хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах талаар санал бодол
<p>Хэрэгжүүлэх түвшинд: ШШГГ-ын харьяа баривчлах байр, НЦҮТөвүүд, Хамгаалах байрын мэргэжилтнүүд, Хүүхдийн тусламжийн утас 108 төвийн холбогдох мэргэжилтэнүүд</p>	<ul style="list-style-type: none"> - Онцгой нөхцөл байдлын үед үйлчлүүлэгчдийн тоо өссөн болон буурсан эсэх - Онцгой нөхцөл байдлын үед НЦҮТөвүүд болон хамгаалах байрууд шаардлагатай үйлчилгээг хүргэж чадаж байгаа эсэх - Хэрэв нэг зэрэг олон үйлчлүүлэгч ирсэн тохиолдолд үйлчилгээг хүртээмжтэй хүргэж чадах эсэх - Одоогийн байгаа хүчин чадлынхаа хүрээнд шаардлагатай үйлчилгээг чанартай хүргэж буй эсэх - Хүний нөөцийн чадавх, боломж ба орон нутгийн нөөц - Онцгой нөхцөл байдлын үед НЦҮТөвүүд болон хамгаалах байрууд, баривчлах төвүүд болон хүүхдийн тусламжийн утасны үйл ажиллагаа, үйлчилгээний ачаалалд өөрчлөлт орсон эсэх - Яаралтай болон онцгой нөхцөл байдалд үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган ажиллах төлөвлөгөө байгаа эсэх

	<ul style="list-style-type: none"> - Хэрэв үйлчлүүлэгч COVID19 –аар халдварлагдсан тохиолдолд нэн тэргүүнд авах арга хэмжээний талаар мэдэж буй эсэх - Онцгой нөхцөл байдлын үед НЦҮТөвүүд болон хамгаалах байрууд санхүүгийн болон бусад нөөцүүдийг хэрхэн шийдвэрлэж буй эсэх - 2020 он дуустал үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй явуулахад хэрхэн ажиллах талаарх санал санаачлага - Онцгой байдлын үед дэх ЖСХ/ГБХ –ын хохирогчдод үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын аюулгүй байдал, ажиллах нөхцөл хангагдаж буй эсэх - Онцгой нөхцөл байдлын үед хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах талаар санал бодол - Онцгой байдлын үед дэх ЖСХ/ГБХ –ын хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд өгөх санал зөвлөмж
<p style="text-align: center;">ЖСХ/ГБХ –ийн холбогдогч хүчирхийлэл үйлдэгч</p>	<ul style="list-style-type: none"> - Та яагаад баривчлах төвд ирсэн бэ? - Хүчирхийлэл үйлдэхэд юу нөлөөлсөн гэж бодож байна вэ? Яагаад хүчирхийлэл үйлдсэн гэж бодож байна вэ? - COVID 19 цар тахлын үеийн хорио цээр, хязгаарлалтын улмаас таны хувийн амьдрал болон ажил төрөлд бэрхшээл хүндрэл тулгарсан уу? Танай гэр бүлийн хувьд мөн адил бэрхшээл тулгарсан болов уу? - Таны бодлоор таныг хүчирхийлэл үйлдэхээс чухам юу хамгаалж чадах байсан бол? - Та ямар ажил эрхэлдэг вэ? Хорио цээрийн үед та болон танай гэр бүлийн гишүүд өдрийг хэрхэн өнгөрөөж байна вэ? - Хорио цээрийн үед гэр бүлийн гишүүдтэйгээ хамтдаа ихэвчлэн цагийг хэрхэн өнгөрөөж байна вэ? Гэр бүлийн гишүүдтэйгээ харилцаж буй таны харьцаа хэр нээлттэй бөгөөд дотно вэ? - Энэхүү цар тахлын үед та өөрийгөө сэтгэл санааны хямрал болон санхүүгийн бэрхшээлд орсон гэж үзэж байна уу? - Дээр дурдсан бэрхшээлүүд танд болон танай гэр бүлд хэрхэн нөлөөлсөн бэ? - Та өөрт тулгарсан бэрхшээлийг даван туулах гэж оролдсон уу? Танд ямар тусламж, дэмжлэг хэрэгтэй байсан бэ? - Таны бодлоор COVID 19 цар тахал, хорио цээрийн үеийн сэтгэлзүйн дарам болон бусад тулгамдсан асуудлыг даван туулахад хувь хүмүүс болон гэр бүлд ямар дэмжлэг, тусалдцаа хэрэгтэй гэж үзэж байна вэ?

	<ul style="list-style-type: none"> - Энэхүү цар тахлын хорио цээрийн үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэдэд хэрхэн хүргэвэл зүгээр гэж та бодож байна вэ?
ЖСХ/ГБХ –ийн хохирогч	<ul style="list-style-type: none"> - Та яагаад НЦҮТ /Хамгаалах байранд ирсэн вэ? - Таныг хүчирхийлэлд өртөхөд юу нөлөөлсөн гэж бодож байна. Тэр яагаад хүчирхийлэл үйлдсэн гэж бодож байна вэ? - COVID 19 цар тахлын үеийн хорио цээр, хязгаарлалтын улмаас таны хувийн амьдрал болон ажил төрөлд бэрхшээл хүндрэл тулгарсан уу? Танай гэр бүлийн хувьд мөн адил бэрхшээл тулгарсан болов уу? - Таны бодлоор таныг хүчирхийлэлд өртөхөөс чухам юу хамгаалж чадах байсан бол? - Та ямар ажил эрхэлдэг вэ? Хорио цээрийн үед та болон танай гэр бүлийн гишүүд өдрийг хэрхэн өнгөрөөж байна вэ? - Хорио цээрийн үед гэр бүлийн гишүүдтэйгээ хамтдаа ихэвчлэн цагийг хэрхэн өнгөрөөж байна вэ? Гэр бүлийн гишүүдтэйгээ харилцаж буй таны харьцаа хэр нээлттэй бөгөөд дотно вэ? - Энэхүү цар тахлын үед та өөрийгөө сэтгэл санааны хямрал болон санхүүгийн бэрхшээлд орсон гэж үзэж байна уу? - Дээр дурдсан бэрхшээлүүд танд болон танай гэр бүлд хэрхэн нөлөөлсөн бэ? - Та өөрт тулгарсан бэрхшээлийг даван туулах гэж оролдсон уу? Танд ямар тусламж, дэмжлэг хэрэгтэй байсан бэ? - Таны бодлоор COVID 19 цар тахал, хорио цээрийн үеийн сэтгэлзүйн дарам болон бусад тулгамдсан асуудлыг даван туулахад хувь хүмүүс болон гэр бүлд ямар дэмжлэг, туслалдцаа хэрэгтэй гэж үзэж байна вэ? - Энэхүү цар тахлын хорио цээрийн үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэдэд хэрхэн хүргэвэл зүгээр гэж та бодож байна вэ?
Хүүхэд Хөгшдийг Ивээх Төв ТББ, Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо ТББ, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв ТББ	<ul style="list-style-type: none"> - Онцгой байдлын үед дэх ЖСХ/ГБХ - ын шалтгаан бодит байдал - Онцгой байдлын үед дэх ЖСХ/ГБХ - д нөлөөлж буй хүчин зүйлс - Онцгой байдлын үед дэх ЖСХ/ГБХ - ын хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, хамгаалах болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд өгөх санал зөвлөмж
Хан-уул дүүрэг, Баянзүрх дүүргийн хамтарсан багийн гишүүд, нийгмийн ажилтнууд	<ul style="list-style-type: none"> - Онцгой нөхцөл байдлын үед ажлын ачаалал буурсан, нэмэгдсэн шалтгаан нөхцөл байдал

	<ul style="list-style-type: none">- Онцгой байдлын үед дэх ЖСХ/ГБХ - ын шалтгаан бодит байдал- Онцгой байдлын үед дэх ЖСХ/ГБХ - д нөлөөлж буй хүчин зүйлс- Онцгой байдлын үед дэх хүүхдийн эрх хамгаалал, ялангуяа эрсдэлт бүлгийн хүүхдүүдийн эрх хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа- Онцгой нөхцөл байдлын үед хамтын ажиллагаа хэрхэн сайжруулах эсэх- Онцгой байдлын үед дэх ЖСХ/ГБХ - ын хохирогчдод үзүүлэх үйлчилгээ, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд өгөх санал зөвлөмж
--	--

...oooOOOooo...